

## Өвөр монголын хөгжмийн зохиолч Ялалтын төгөлдөр хуурын бүтээлд хийсэн ажиглалт

Мөнхбаатарын Хүсэл<sup>1,\*</sup>  
Хайдавын Ариунаа<sup>1</sup>

<sup>1</sup> Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,  
Улаанбаатар, Монгол Улс

ORCID: <https://orcid.org/0009-0004-1842-1062>

ORCID: <https://orcid.org/0009-0001-4714-1543>

\* Холбоо барих зохиогч: [baolier0611@gmail.com](mailto:baolier0611@gmail.com)

**Хураангуй:** Энэхүү өгүүллээ Өвөр монголын хөгжмийн зохиолч Ялалтын бүтээлүүд, тэдгээрийн онцлог хэв маягийг тодруулан дүн шинжилгээ хийж, энэ бүхнээр дамжуулан Өвөр монголын хөгжмийн зохиолчдын төгөлдөр хуурт зориулсан бүтээлийн хөгжил дэвшлийг тодорхойлон таниулах зорилгоор бичсэн болно. Зорилгын хүрээнд Өвөр монгол дахь төгөлдөр хуурын урлагийн хөгжил дэвшлийн талаар товч танилцуулж, хөгжмийн зохиолчдын төгөлдөр хуурт зориулсан бүтээлийн төрөл зүйлийг тодруулан, хөгжмийн зохиолч Ялалтын “Төгөлдөр хуурын түүвэр”, тодорхой бүтээл дээр нь жишээлэн зохиомжийн хэв маяг, онцлогийг тодруулан илрүүлж, цаашид үргэлжлүүлэн судалгаа хийх сэдлийг өгч, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулахыг зорилтоо болгосон. Энэ үүднээс бид хэвлэгдсэн ном ноот, эрдэмтэн судлаачдын өгүүлэлтэй танилцаж, цуглуулан, бүтээлүүдийг төрөл зүйлээр нь ангилан, сонгосон бүтээлийг задлан шинжилж, өөрийн ажиглалтаа нэгтгэн дүгнэхийг хичээсэн юм.

Тухайлбал, хөгжмийн зохиолч Ялалтын “Төгөлдөр хуурын түүвэр”-т нийт 41 бүтээл багтсан байгаагаас монгол хэв намба, онцлогтой 15 бүтээл (энэ нь түүвэр дэх бүтээлийн 37%), орчин үеийн шинэ, шинэлэг арга техникээр туурвисан 26 (63%) бүтээл байна. Үүнээс харахад, Өвөр монголд хөгжмийн зохиомжийн дэг сургалт хожуу бүрэлдэн хөгжсөн боловч өнөө өөрийн гэсэн хөгжмийн зохиолчидтой болж, төгөлдөр хуурын урлагийн хөгжилд өөрсдийн хувь нэмрийг оруулан байгааг илэрхийлэхийн зэрэгцээ хөгжмийн зохиолчид, тухайлбал Ялалт, уламжлалт болон орчин үеийн арга техникийг хослуулан ашиглаж бүтээлээ туурвиж буй нь өвөр монголын хөгжмийн зохиолчид дэлхийн хөгжмийн зохиомжийн арга техникээс хоцрон хаягдаагүй, эрэл хайгуулыг хийсээр байгаа гэдгийг илэрхийлж байна.

**Түлхүүр үгс:** *зохиомж, төрөл зүйл, төгөлдөр хуурын бүтээл*

## Observations on inner Mongolian composer Yalalt (Yeerda)'s piano compositions

Huzele Munkhbaatar<sup>1,\*</sup>  
Ariunaa Khaidav<sup>1</sup>

<sup>1</sup> School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0004-1842-1062>

ORCID: <https://orcid.org/0009-0001-4714-1543>

\* Corresponding author: [baolier0611@gmail.com](mailto:baolier0611@gmail.com)

**Abstract:** This article was written to identify and analyze the works of Inner Mongolian composer Yalalt (Yeerda) and their characteristic styles, and through this, to understand the development and progress of the piano works of Inner Mongolian composers. Within the scope of the goal, the development of Inner Mongolia's piano art is briefly introduced, the types of piano works by composers are clarified, and the style and characteristics of the compositions are explored, taking composer Yeerda's "Piano Collection" as an example, the goal was to study and continue to study a specific work. From this perspective, we looked into books, notes, and articles published in academic journals, collected them, classified the works by genre, analyzed the selected works, and summarized our observations.

For example, composer Yeerda's "Piano collection" includes 41 works, 15 of which have Mongolian style and characteristics (37% of the collection's works) and 26 (63%) works created using new and innovative modern techniques. From this, we can see that composition education developed late in Inner Mongolia, but now it has its own composers, and they (such as Yeerda) are creating works using combinations, expressing their contribution to the development of piano art. This shows that composers are not lagging behind and are still exploring world music composition techniques.

**Keywords:** *piano composition, genre, stylistic writing, analysis*

### Оршил

Шанхай хотын хөгжмийн дээд сургуулийг зохиолч, удирдаачийн мэргэжлээр төгссөн хөгжмийн зохиолч Ялалт нь найрал хөгжим, гоцлол, цөөхүүл хөгжим, бүжгийн олон сайхан бүтээлүүдээрээ нэр алдраа дуурьсгаж яваа тэргүүлэх уран бүтээлчдийн нэг билээ. Тэр дундаа монгол үндэстний дуу хөгжмийн онцлог хэв намба, өрнө дахины хөгжмийн урлагт буй болж, өнөөг хүртэл хөгжин дэвжсэн сонгодог уламжлал, өмнөх зууны шинийг эрэлхийлэгчдийн эрэл хайгуулын үр улбаа болсон шинэлэг хэв маягийг хослуулан туурвисан түүний төгөлдөр хуурын бүтээлүүд нь түүнийг Өвөр монголын хөгжмийн зохиомжийн дэг бүрдэл, хөгжлийн нэгэн тод төлөөлөл мөн гэдгийг нь гэрчилж чадна. Түүний бүтээл туурвилын онцлогийг тодруулах зорилгыг хэрэгжүүлэх үүднээс Өвөр монголд хөгжмийн зохиомж болоод төгөлдөр хуурын дэг бүрэлдсэн

талаар товч танилцуулж, хөгжмийн зохиолчдын төгөлдөр хуурт зориулсан бүтээлийн төрөл зүйлийг тодорхойлон, хөгжмийн зохиолч Ялалтын төгөлдөр хуурт зориулсан тодорхой бүтээлүүдийг нь сонгон шинжиж, онцлог хэв маягийг тодруулан илрүүлэх зорилтуудыг тавин хэрэгжүүлэхийг хичээлээ. Судалгааны ажлууд, цахим эх сурвалж, сэтгүүл, ном товхимлуудаас үзэхүл өвөр монголын хөгжмийн зохиолч Ялалтын төгөлдөр хуурт зориулсан бүтээлд хийсэн судалгааны ажил ерөнхийдөө ховорхон харагдаж байна. Ихэнх судалгааны ажил нь зохиогч, зохиолын талаар дөмөгхөн танилцуулсан өгүүллийн шинжтэй, мөн олон тооны давхацсан ажил гарсан байдаг. Эндээс тухайлан түүхэн холбогдол (Ли Ман 2010), онцлог, хөгжимдөх арга барил (Үүдан 2016), уран сайхны талаар (Фэнсон 2013) хийсэн судалгааны өгүүлүүдийг дурдаж болох байна.

### **Судалгааны арга зүй**

Бид энэхүү өгүүлэлдээ баримт бичиг, мэдээлэл цуглуулах /хөгжмийн зохиолч Ялалтын төгөлдөр хуурын түүвэр дэх 40 гаруй бүтээл болон түүний уран бүтээлийн замналтай хамаатах материал/, ажиглалт хийх /төрөл зүйл, зохиомжийн хэв маяг, илэрхийллийн арга хэрэглүүрийн талаар тодруулах зорилгоор/, задлан шинжлэх /онцлогоор тодрох 2 бүтээл дээр/, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг ашигласан болно.

### **Судалгааны үр дүн**

XIX-XX зууны хоорондох хэдэн жилд хятадын нийгэм, түүхийн чиг хандлагад өөрчлөлт гарч, барууны нийгэм ертөнцтэй соёл урлагийн харилцан солилцоо ихэссэний үр дүнд барууны хөгжмийн зэмсэг болох төгөлдөр хуурт суралцаж, энэ зэмсгээр хөгжимдөж, хөгжмийн зохиолчид уг зэмсэгт зориулсан бүтээлүүдийг туурвиж эхэлсэн юм. 1915 онд Хятад улсын хөгжмийн зохиолч Жао Юан Рэн хятадын түүхэн дэх анхдагч төгөлдөр хуурын бүтээл “Энх тайваны марш”-г туурвиснаас эхлэн Хятад улсын өөрийн төгөлдөр хуурын бүтээлийн үндэс суурь бүрэлдсэн гэж үзэж болно. 1934 онд Хэ Лю Тингийн зохиосон “Хоньчны лимбэ” хэмээх зохиол нь хятадын төгөлдөр хуурын туурвих ажлыг урлагийн бүтээлийн алхам руу хүргэж, хятадын уламжлалт 5 эгшигт хөг эгшиглэгээ (пентатоник), өрнийн 7 эгшигт хөг эгшиглэгээний (диатоник) агуулгыг илүү сайн нэгтгэсэн гэж үздэг. (Ан Лэ 2011, 164-165).

БНХАУ байгуулагдахаас (1949 он) өмнө хятадын төгөлдөр хуурын бүтээл туурвих ажил урагштай байсан боловч монголын хэв маягтай төгөлдөр хуурын бүтээлийн хувьд хараахан хөгжжөөгүй байсан. БНХАУ байгуулагдсаны дараа уран сайхны сэтгэлгээний шинэ чиг хандлага нь олон үндэстний хөгжмийг бэхжүүлэн, сайжруулахад түлхэц болж, монгол хэв маягийн төгөлдөр хуурын бүтээлүүд хятадын урлагийн түүхэн тавцанд гарч эхэлсэн билээ.

Өвөр монголын төгөлдөр хуурын урлаг дахь монгол хэв маяг, онцлогтой бүтээлүүдийг туурвиж эхэлсэн нь хятад хөгжмийн зохиолчид байсан бөгөөд үүнд Сан Түн зохиолчийн “Зүүн монголын ардын дуунаас сэдэвлэсэн төгөлдөр хуурын долоон аялгуу” (1952 он) нь хамгийн их төлөөлөл болсон юм. Мөн 1952 онд хэвлүүлсэн Лү Хуа Бө-гийн “Хятад ардын дуу, төгөлдөр хуурын түүвэр”-т “Тоорын цэцэг”, “Монгол ардын дуу” зэрэг монгол ардын дуу хөгжмөөс сэдэвлэсэн төгөлдөр хуурын бүтээлүүд бий. 1994 онд Ли Ин Хай-ын хэвлүүлсэн “Хятадын

ардын дуунаас ирэлтэй 50 төгөлдөр хуурын бүтээл” түүвэрт “Гаадаа мээрэн”, “Да Лиан Чэн” (打连成) зэрэг монгол ардын дуунаас сэдэвлэж зохиосон төгөлдөр хуурын зарим бүтээлүүд багтсан байна (Яруу 2013, 145-148).

1996 онд хөгжмийн зохиолч Мэргэжих “Уулан тахилга” нэртэй бүтээлийн түүврээ гаргасан нь монгол хөгжмийн зохиолчийн эх орондоо албан ёсоор хэвлүүлсэн анхны төгөлдөр хуурын гоцлолын түүвэр болсон юм. Энэ үеэс монголын хөгжмийн зохиолчид өөрийн үндэстний хөгжмийн арга техник, аялга эгшиглэгээнд тулгуурласан төгөлдөр хуурын бүтээлүүд туурвиж эхэлжээ.

2001 онд Ли Ши Шианы “Монгол хэв маягийн төгөлдөр хуурын аялгуу”, Тиеэ Ины “Төгөлдөр хуурт зориулсан өвөр монголын 60 ардын дуу”, 2003 оноос Лүн Шианы “Төгөлдөр хуурын цомог”, “Төгөлдөр хуурт зориулсан хятадын алдартай дуунууд болон анхан шатны сургалтын дасгалууд” дэх “Нуунзаяа”, “Сийлсэн эмээл”, “Гаадаа мээрэн”, “Тал нутгийн хайр” бүтээл, Сэрэннадмидын “Монгол ардын арван хоёр дуу, төгөлдөр хуурын түүвэр”, Цэцэнцогтын гоцлол бүтээлүүд “Нуунзаяа уран сэтгэмж”, “Вальс”, “Монгол бүжгийн аялгуу”, төгөлдөр хуурын чуулбар “Хүүхэд насны дурсамж”, төгөлдөр хуурын цуврал “Дөрвөн улирлын тал”, Хишигтийн “Галуу дууны сэдэвт хувилбарууд” (2009), гоцлол бүтээлүүд “Хорчины рапсоди” (2018), “Цэцэглэн дэлгэрэх” (2018), Ялалтын “Төгөлдөр хуурын цомог”, Шилийнхүүгийн “Төгөлдөр хуурын нэгдүгээр концерт” болон Ангирын “Төгөлдөр хуурын нэгдүгээр концерт” зэрэг бүтээлүүд бүтээгдэж дэлгэрэн хөгжсөн байна (Ли Ман 2010). Эдгээр нь барууны дан (гомофони) болон нийлэл (полифоник) эгшиглэнгийн зохиомж бүтцийг ашиглан хөгжмийн үндэстний онцлогийг илэрхийлэх гэсэн шинэ оролдлого, эрэл хайгуул байсан юм. Ийнхүү өвөр монголын хөгжмийн зохиолчид үндэстний соёлын сэтгэлгээг хөгжүүлэхийн зэрэгцээ монгол хэв маягийн төгөлдөр хуурын бүтээлийг улам гүнзгийрүүлэн хөгжүүлж байна.

Өвөр монголын хөгжмийн зохиолчдын төгөлдөр хуурт зориулсан бүтээлүүдийг харвал дараах төрөл зүйлээр туурвисан байгаа нь ажиглагдаж байна. Үүнд бэсрэг буюу жижиг хэлбэрийн аяз /тухайлбал ардын дуу, бүжгийн аяз, вальс, прелюди, фантази, ноктюрн, баркарола г.м/, төгөлдөр хуурын чуулбар /сюита/, төгөлдөр хуурын цуврал бүтээлүүд /Оршил ба Фуг/, хувилбар аяз /вариаци/, хөрвүүлсэн бүтээл, төгөлдөр хуурын хоршил /дуэт/, рапсоди, баллада, хүүхдийн аяз /бүүвэйн дуу/, том хэлбэрийн соната, концерт, хос төгөлдөр хуурын бүтээл байна. Энэ бүтээлүүд ерөнхийдөө ардын дууны эгшиглэгээ, хэмнэлийн онцлог, дуурьслын хэв намбыг хадгалсан байдаг нь тод харагддаг. Эдгээрээс ардын дууны найруулга нь бүтээлүүдийн зохих хувийг эзэлж байна.



Зураг 1. Бүтээлүүдийн эзлэх хувь

Энд орчин үеийн төлөөлөх чанартай монгол хөгжмийн зохиолч Ялалтын нэгэн төгөлдөр хуурын түүврээс жишээ татъя.

Ялалт нь монгол үндэстэн, хөгжмийн зохиолч, удирдаач, өвөр монголын Урлагийн их сургуулийн гавьяат профессор, хөгжмийн зохиолчийн магистрын удирдагч багш. 1988 онд Шанхай хотын хөгжмийн их сургуулийг зохиолч, удирдаачийн мэргэжлээр төгссөн. 2006 онд ОХУ-ын Москва хотын хөгжмийн консерватори, Москвагийн Улсын багшийн их сургуулийн хөгжмийн факультетад хөгжмийн зохиолч, удирдаач мэргэжлээр үргэлжлүүлэн суралцсан байна. Түүний төлөөлөх бүтээлүүдээс дурдвал:


- Үндэсний найрал хөгжимд зориулсан симфони: “Торгоны замын бэлчээр”, “Умард Шинжааны дуулал”, “Тэмцэл” зэрэг
- Симфони: “Бэлчээрийн уран зургийн чуулбар”, “Ойрадын хэв маяг”, “Дүүлэлт” зэрэг
- Дууны бүтээлүүд: “Бэлчээрийн ерөөл”, “Найман мод” зэрэг
- Төгөлдөр хуурын бүтээл: “Төгөлдөр хуурын гучин хоёр прелюди”, “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр” зэрэг
- Бүжгийн жүжгийн бүтээл: “Морин хуурын эгшиг”, “Цаст уулын монголчууд” гэх мэт байдаг.

Хөгжмийн зохиолч Ялалт төгөлдөр хуурт зориулсан зохиолуудаасаа дээжлэн “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээ хэвлүүлсэн нь нийт 41 бүтээлтэй.

*Хүснэгт 1. Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-т орсон зохиолын жагсаалт*

№	Бүтээл	Он	№	Бүтээл	он
1	Соната	1984	2	Баллад	1985
3	Монгол бүжгийн аялгуу	1984	4	Андайн сэдэвт хувилбарууд	2006
5	Гаадаа мээрэн	2000	6	Нутгаа санах	2006
7	Ноктюрн	1984	8	Ноктюрн	1984
9	Бүүвэйн дуу (Берсеус)	2007	10	Хүүхдүүдэд зориулсан дуу	2007
11	Жижиг амьтад	2007	12	Жижиг амьтдын тоглоом	2007
13	Хүүхдийн тоглоом	2007	14	Хүүхэд насны дурсамж	2007
15	Хүүхэд насны тоглоом	2007	16	Казак бүжгийн аялгуу	2008
17	Хуучин дуу	2006	18	Баркарола	2006
19	Робот хүүхэддэй	2007	20	Шоргоолжны нүүдэл	2007
21	Тар бүжиг	1991	22	Галын бүжиг	2006
23	Архин дуу	2008	24	Савардан бүжгийн сэдэвт хувилбар аяз I	2006

25	Савардан бүжгийн сэдэвт хувилбар аяз II хувилбарууд II	2006	26	Савардан бүжгийн сэдэвт хувилбар аяз III III	2006
27	Домог	2008	28	Прелюдия 1	2007
29	Прелюдия 2	2007	30	Прелюдия 3	2007
31	Прелюдия 4	2007	32	Прелюдия 5	2007
33	Прелюдия 6	2007	34	Прелюдия 7	2007
35	Прелюдия 8	2007	36	Прелюдия 9	2007
37	Прелюдия 10	2007	38	Прелюдия 11	2007
39	Прелюдия 12	2007	40	Прелюдия 13	2007
41	Прелюдия 14	2007			



*Зураг 2. Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-т орсон бүтээлүүдийн эзлэх хувь*

Хөгжмийн зохиолч үндэсний болон өрнийн хөгжмийн зохиомжийн хэв маяг, арга техникийг хослуулан эдгээр бүтээлүүдээ туурвисан байгаа нь ажиглагддаг. Тухайлбал, энэ түүврийн №3 “Монгол бүжгийн аялгуу” нь сонгодог хэв маягийг хадгалсан байдаг бол №32 “Прелюдия 5” нь орчин үеийн арга техникийг өвөрмөцөөр ашигласан нь тодорхой сонсогддог.

**Монгол бүжгийн аялгуу**

Ялалтын төгөлдөр хуурын бүтээлүүдэд багтсан уламжлалт хэв маягийн бүтээлүүдийн аялгуунууд бүгд монгол хэв маягийг шингээсэн, эх бүтээлүүд бөгөөд эдгээрийн нэг тод жишиг нь “Монгол бүжгийн аялгуу” юм.

*Хүснэгт 2. “Монгол бүжгийн аялгуу” зохиолын бүтэц*

Хэсэг	А	Б	А
Хурд	Moderato	Allegro	Moderato
Айзам	1-26 такт	27-72 такт	73-93 такт
Хөг эгшиглэгээ	D dur	d moll	D dur
	дуулалт	бүжгийн	дуулалт

Нийлмэл 3 хэсэгт хэлбэрт зохиогдсон энэ зохиолын онцлог нь дараах байдлаар тодорхойлогдож болох байна. Үүнд:

1. Зохиолын аялгууг бүхэлд нь таван эгшигтийн эгшиглэгээний аясаар, хэсэгчилсэн өнгө аясгүйгээр гүйцэтгэсэн. Тиймээс дуурьсал дуугаралт нь хүмүүст үндэсний хэв маягийг хүчтэй төрөгдүүлдэг.
2. Холын үсрэлтүүдийг ашигласан. Монгол ардын дуу, хөгжимд холын зайн үсрэлт нэлээд тохиолддог нь монгол хэлний дуудлагын онцлогтой нягт холбоотой. Ийм үсрэлтүүд нь монгол хөгжмийн нэгэн чухал илэрхийллийн арга бөгөөд аялгууны явцын хувьд маш өвөрмөц онцлогтой. Холын зайн интервалын үсрэлтийг ашиглах нь аялгууг чанга, эрч хүчтэй, шинэлэг болгож, монгол хүний эрх чөлөөтэй, хязгааргүй, урам зориг ихтэй чанарыг харуулахад дөхөм болдог.



Зураг 3. “Монгол бүжгийн аялгуу”<sup>1</sup> зохиолын дунд хэсгийн гол аялгуу



Зураг 4. “Монгол бүжгийн аялгуу”<sup>2</sup> зохиолын эхлэл хэсэг


3. Давтал хэсэг. Ийнхүү эхлэлийг дахин давтах нь Ялалтын төгөлдөр хуурын бүтээлүүд дэх хамгийн түгээмэл аялгуу хөгжүүлэх арга юм. Аялгууг хөгжүүлэх

<sup>1</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

<sup>2</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

хэлбэр нь хөгжмийн анхны санааг тасралтгүй давтах үйл явц бөгөөд энэ нь тухайн сэдвийн сэтгэгдлийг гүнзгийрүүлж чаддаг. Монгол бүжгийн хөгжмийн таниулга хэсэг дэх аялгууг хөгжүүлэх үндсэн арга техник нь сэдвийн материалын өөрчлөлт, хөгжил нь өөрөө өөрчлөлтийн давталт юм.

Зохиол D их хөгт эгшиглэж эхлэх бөгөөд энэ хэсэг нь эерэг сэтгэлийн хөдлөлийг илэрхийлэхийн тулд D их хөгийн гол хам эгшгийг оршил болгон ашигладаг. Сэдвийн сэдэл нь а, в гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Гуравлалын хэмнэлээр урагшилж буцаад хагас ноотын аялга руу үсэрч, жижиг чимэглэлийн ноот нэмсэнээр аялгуу нь дуулалт чанартай болдог. Дараагийн хэллэгүүд нь эгшгийн өндөр нам, зайцын (интервалын) хувьд сэдэл хэллэгтэй бүрэн нийцдэг.



Зураг 5. “Монгол бүжгийн аялгуу” зохиолын А хэсгийн 2 дахь үеийн эхлэл

Хам эгшгүүдэд нэмэлт эгшгүүдийг ашиглах нь үндсэн гурвал эгшгүүдийн бүтцийг өөрчлөхгүйгээр өнгө, төвлөрөл, зохицлын илэрхийлэл нөлөөг нэмэгдүүлэх боломжтой. Хам эгшгийн бус эгшгүүдийг нэмэлтээр ашигласан аялгуу нь бие даасан, хөдөлгөөнгүй араншинтай байна.

“Монгол бүжиг”-т Б хэсгийг зохиолч d бага хөгт шийдсэн нь хурдны хувьд илүүтэй цоглог, хөнгөн байгаа нь ч энэхүү зохиолын бүтцэд тод ялгарамж үүсгэнэ.




Зураг 6. “Монгол бүжгийн аялгуу”<sup>3</sup> зохиолын Б хэсгээс

Зохиолч энэ хэсэгтээ хувилбарт хөгжүүлгийн аргаас гадна /Б хэсэг 3 хувилбараас бүрдэнэ/ хөг шилжилтийн аргыг ашигласан байх ба үүнийгээ мөшгөлийн арга техникээр гүйцэтгэжээ. Ингэж ижил буюу ойролцоогоор ижил зайц (интервал), хэмнэлийг хадгалж, өөр өөр өндөрлөгт давтах байдлаар хөгжмийг дээд цэгт хүргэн хөгжүүлэх аргыг хөгжмийн зохиолч олонтаа хэрэглэдэг нь

<sup>3</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011




ажиглагддаг. Хөг шилжилтийн ийм явц нь ихэвчлэн чөлөөтэй мэт харагддаг ч “Монгол бүжиг”-ийн дундах аялгууны мөшгөлийн явц нь хэмнэлийн онцлогоо хадгалсан, ижил бүтэцтэй байдаг тул харш дуурьслын (диссонансын) асуудал гардаггүй.



Зураг 7. “Монгол бүжгийн аялгуу”<sup>4</sup> зохиолын Б хэсгийн мөшгих давталт /өгссөн/

Мөн дээш чиглэсэн хөдөлгөөн нь хөгжмийн бүтээлд эрч хүч, урам зориг нэмж, илүү сайн хөгжүүлэх боломжийг олгодог. Энэхүү хэсгийн эх загвар нь “Монгол бүжгийн хөгжим”-ийн төв аялгууны эх материал бөгөөд хэмнэл, цохилгын байрлал, зайцын хамаарал, чиглэл зэрэг нь эх материалтай бүрэн нийцдэг. Үүний дараа нэн өөр, доош чиглэсэн аялгууны илэрхийлэл явагдана.



Зураг 8. “Монгол бүжгийн аялгуу”<sup>5</sup> зохиолын Б хэсгийн мөшгих давталт /уруудсан/

Аялгууг доошоо чиглүүлэн мөшгих нь дээшээ урагшлахтай адил эерэг нөлөө үзүүлэхгүй. Энэ нь дөрөвцийн харьцааны дарааллаар үргэлжилж хурцадмал, тогтворгүй байдлыг нэмэгдүүлнэ. Б хэсэг дэх хувилбарласан өөрчлөлтүүд нь ч мөн хөгжмийн зохиолчийн аялгуу хөгжүүлэх нийтлэг аргын нэг юм. Ялалтын

<sup>4</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

<sup>5</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

уламжлалт хэв маягтай төгөлдөр хуурын бүтээлүүдэд зохиогч үргэлжилсэн хөгжүүлэлт эсвэл оргилд нь түлхэх зорилгодоо хүрэхийн тулд хувиргах аргыг ийнхүү ашигладаг.



Зураг 9. “Монгол бүжгийн аялгуу”<sup>6</sup> зохиолын Б хэсгийн оргил

“Монгол бүжиг”-т хэрэглэгдэж буй зарим дэд хам эгшгүүд нь зохиолын дуурьслын (гармоник) нөлөөг баяжуулж, хүмүүст сонголын шинэ мэдрэмжийг төрүүлдэг. Хэдийгээр бүхэл бүтэн хөгжимд дэд хам эгшгүүдийн хэрэглээ олон байдаг ч хөгжмийн дуурьсал уламжлалт хэв маягаа хадгалан байгаа нь харагдаж байна.

### Прелюди № 5

Прелюди нь хөгжмийн зохиолчийн орчин үеийн арга техникийг ашиглан бүтээсэн бүтээлийн нэг юм. Эдгээр бүтээлүүд нь уртаараа харьцангуй бага, зохиолчийн ХХ зууны арга техникийг суралцсан дадлагын бүтээл мөн гэж ойлгогддог. Ийм орчин үеийн чиг хандлагатай бүтээлүүд дэх хамгийн түгээмэл хэрэглэгддэг техник бол Арван хоёр эгшигтийн (додекафони) техник юм.

Арван хоёр эгшигтийн техник нь хөг үгүйсгэлт хөгжмийн хөгжлийн тод илрэл болдог. Энэ техникийг анх удаа туршиж үзсэн хүн бол австрийн хөгжмийн зохиолч Йозеф Маттиас Хауэр<sup>7</sup> байсан бөгөөд тэрээр бүтээлүүддээ арван хоёр эгшигтийн техникийг нээж, хожим А.Шёнберг<sup>8</sup> арван хоёр эгшигтийн техникийг бүхэл бүтэн систем болгон журамласан ажээ. Шёнбергийн төрсөн нутгийн, түүний

<sup>6</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

<sup>7</sup> И.М.Хауэр, 1883-1959 он, австрийн хөгжмийн зохиолч, хөгжмийн онолч. Бүтээлдээ арван хоёр эгшигтийн тогтмолыг нээн илрүүлж, судалж, системчилж эхэлжээ.

<sup>8</sup> А.Шёнберг, 1874-1951 он, австри-америкийн хөгжмийн зохиолч, хөгжмийн онолч, барууны модернист хөгжмийн төлөөлөл

үеийн Йозеф Маттиас Хауэр нь Шёнбергийн арван хоёр эгшигтийн техниктэй хамаарахгүй бөгөөд Хауэрийн арга барил журамлагдаагүй.

Бусад хөгжмийн зохиолчид арван хоёр эгшигтийн цувааг системчлэн ашиглаж байсан боловч Шёнбергийн аргыг түүхэн болон гоо зүйн хувьд хамаагүй илүү ач холбогдолтой нь гэж үздэг. Энэ нь олон хөгжмийн зохиолчдыг дагаж мөрдөхөд хүргэсэн бөгөөд ХХ зууны хамгийн чухал хөгжмийн арга техникийн нэг болжээ.

Арван хоёр эгшигтийн техникийн үндэс бол арван хоёр эгшигийн цувааны өрөг бүхнийг хам эгшигийн бүтцэд тухайн хөг-эгшиглэгээний хүрээнд оруулж болох хөг-эгшиглэгээний зохиролын журам юм (Жанцанноров 1996, 107). Арван хоёр эгшигийн техникийг дэлгэрүүлэх зорилгоор, дараа хэдэн аргыг хэрэглэх болов.

1. Эгнээ бол хроматик цувааны бүх арван хоёр ноотны тусгай журам юм / наймцын байрлалыг харгалзахгүй/.
2. Эгнээнд ноот давтагдахгүй.
3. Эгнээ зай хадгалалтын өөрчлөлтөд хамаарахгүй байж болно. Өөрөөр хэлбэл, эхний хэлбэрээс гадна тонгорол, ухралт буюу тонгорол-ухралтаар илэрч болно.
4. Эгшигийн тусгаарлагдсан давталтуудыг мөн зөвшөөрнө (Мэн Цю 1997).

Хөгжмийн зохиолч Ялалт “Прелюдия 5” зохиолоо чөлөөт арван хоёр эгшигийн техникээр бичсэн. Энэ бүтээл нь янз бүрийн 12 эгшигийн дарааллыг (бүрэн болон бүрэн бус хэлбэрээр) багтаасан бөгөөд ноотууд нь тодорхой дарааллаар харагдахгүй, мөн баруун гарын аялгуу болон зүүн гарын (басс) шугамаар тархсан байдаг. Энэ бол чөлөөт хэрэгжилтийн нэг илрэл юм.

Прелюдия 5 зохиолд арван хоёр эгшигтийн нийт арван долоон дарааллыг янз бүрийн хэлбэрээр ашигласан байна. Жишээлбэл:

Анхны дараалал нь:




Зураг 10. “Прелюди №5”<sup>9</sup> -ын эхлэл хэсэгт буй арван хоёр эгшигтийн эхний дараалал

5-р дарааллын төгсгөлийн ноот нь 6-р дарааллын эхний ноот болно.



<sup>9</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011



Зураг 11. “Прелюди №5”<sup>10</sup> -н 5, 6-р дарааллын уулзвар

6, 7, 8-р дараалал нь давхардан дараах гурван айзамд тархан байрласан байна.



Зураг 12. “Прелюди №5”<sup>11</sup> -н 6, 7 дахь дараалал

Энд мөн басс шугамын хоёр айзамд бас бүрэн арван хоёр эгшгийн дараалал тархсан байгааг үзэж болно.



Зураг 13. “Прелюди №5”-н 8 дахь дараалал (8-9-р айзмын зүүн гарын басс шугамд байрлаж буй)

Ийнхүү хөгжмийн зохиолч Ялалтын төгөлдөр хуурын зохиолуудаас дээрх бүтээлүүдийг сонгон задлан шинжилсэн нь энэхүү зохиогчийн түүвэрт эрс ялгаатай зохиомжийн арга техникээр туурвигдсан /монгол хөг аялгууг хадгалсан монгол хэв намбатай болон орчин үеийн зохиомжийн арга техникийг ашигласан бүтээл/ бүтээлүүд байдгийг тодруулж байгаа юм.

<sup>10</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

<sup>11</sup> Ялалтын “Төгөлдөр хуурын бүтээлийн түүвэр”-ээс 2011

### Хэлэлцүүлэг

Төгөлдөр хуурын урлаг, тэр дундаа төгөлдөр хуурт зориулсан хөгжмийн бүтээл туурвилууд бол өвөр монголын хөгжмийн урлагийн түүхэн дэх онцгой болоод чухал үзэгдэл билээ. Энэхүү урлагийн үүсэл, бүрэлдэл, хөгжил нь ӨМӨЗО-ны соёлын бүтээн байгуулалтын үйл явцтай нягт холбоотойн дээр үндэсний хурц тод эрэл ирэлтэй, басхүү өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Энэ сэдвээр хийсэн судалгааны ажил харьцангуй цөөн байгаад анхаарал хандуулах шаардлагатай байгаа юм. Урлаг судлаач Ли Ман “Шинэчлэл нээлтийн 30 жилийн хугацаанд” (Өнгөрсөн зууны 80-д оноос хойшх) монгол хэв намбат төгөлдөр хуурын бүтээл нь монгол үндэстний дуу хөгжмийн хөгжлийн гарцаагүй нэг хэсэг бөгөөд энэ нь монгол үндэстний дуу хөгжим дэлхийн тавцанд гарахын харгуй зам болно. Монгол хэв намбатай төгөлдөр хуурын бүтээлд судалгаа хийх нь хөгжимчид, сонсогчдод энэ үндэстний хөгжмийн урлагийг ойлгоход нэн их дөхөм болгодог (Ли Ман 2010) хэмээсэн нь үнэнд дүйцэж байна.

Энд Ялалт хөгжмийн зохиолчийг төлөөлөл болгон сонгон авсаны учир тэрбээр бүтээл туурвилдаа монгол уламжлалт хөгжмийн илэрхийллийн арга (аялга, хэмнэл, эгшиглэгээ дуурьсал г.м) хэрэглэгдэхүүнийг өрнийн орчин цагийн хөгжмийн арга техниктэй уялдуулан энэ цаг үеийн өвөр монголын төгөлдөр хуурын урлагийн хөгжил, дэвшлийг тодорхойлохуйц бүтээлүүдийг туурвисанд оршино. Ялалтын төгөлдөр хуурын бүтээлүүдийн талаар өвөр монголын урлаг судлаач Фэнсон “..энэ нь янз бүрийн хөгжмийн бүтэц ба найруулгын арга техникийг ашиглан өвөр монголын ардын аялгуунаас өөрчилсөн төдийгүй монголын хөгжмийн тухай өөрийн гүн гүнзгий ойлголтод тулгуурласан. Гармони дуурьслын хувьд барууны уламжлалт их, бага хөг тогтолцоо ба уламжлалт функцийн зохицолууд байдаг” (Фэнсон 2013) хэмээн дүгнэсэн байдаг. Энэ дүгнэлт олон зүйлийг тодорхойлж байгаа боловч судлаачийн ардын аялгууг өөрчилсөн, мөн дуурьсал зохицлын хувьд зөвхөн өрнийн хэв арга барилтай уялдаатай гэдэгтэй миний хувьд санал нэгдэхгүй байгаа юм. Учир нь энд цэвэр монгол хэв намба, эгшиглэгээ дуурьсал бүхий бүтээлүүд ч байхын зэрэгцээ хэдийгээр дийлэнх хувийг эзлэх ч ардын дуу хөгжмөөс сэдэл авч эшлэн, өрнийн гармони дуугаралтаар баяжуулан бүтээсэн бүтээлүүдээс үүдээд монголчуудын ардын дуу хөгжмийн аялгууны эгшиглээ, дуурьсал өөрчлөгдөн хувьсана гэж ойлгож болохгүй.

Харин Ялалт хөгжмийн зохиолчийн зохиомжийн сэдвүүд нь баялаг, олон талт, диссонанс дуурьсал, үсрэлттэй аялгыг ашиглан, аялгуу хөгжүүлэх арвин арга техникээр дамжуулан, уламжлалт таван эгшигтийн тембртэй янз бүрийн хөгжмийн элементүүдийг өрнийн уламжлалт болоод XX зууны орчин үеийн зохиомжийн арга техниктэй нэгтгэсэн гэсэн Үүдан судлаачийн дүгнэлт илүү нийцэж байна. Энд нэмэлтээр дурдах нь дээр хоёр судлаачид хөг үгүйсгэлийн (атональ) арга болон арван хоёр эгшигтийн техникээр туурвисан зарим нэгэн бүтээлийг холилдуулан хуваарилсан байгаа нь ажиглагдсан юм.

## Дүгнэлт

Өвөр монголын төгөлдөр хуурын болоод зохиомжийн дэг сургалт хожуу бүрэлдэн хөгжсөн ч өнөөдөр дэлхий дахинаа энэ улсын хөгжмийн урлагийн хөгжил дэвшлийг таниулах хэмжээний бүтээл туурвилтай, уран бүтээлчидтэй болжээ. Хөгжмийн зохиолчдын төгөлдөр хуурын бүтээлүүдийг үзэхүл олон төрөл зүйлийг хамардаг хэдий ч ихэнх нь бэсрэг төрөлд хамаардаг. Энэ нь ард түмний хөгжмийн мэдрэмж, ойлголтыг хөгжүүлэхэд энэ төрлийн бүтээлүүд хамгийн тохиромжтой гэдгийг бодолцож туурвин байсныг илтгэж буй юм. Хөгжмийн зохиолчдын ийм уламжлалт болоод өрнөдийн сэтгэлгээний хослолд тулгуурлан зохиомжийн олон арга техникийг ашиглан туурвисан бүтээлүүд нь өнөө өвөр монголын хөгжмийн зохиомжийн дэг сургалтын хөгжил дэвшлийн толь болж, төгөлдөр хуурын бүтээлийн урын сангийн баяжилтад томоохон хувь нэмрийг оруулж байгаа билээ.

Энэ урлагийн төлөөлөл болсон хөгжмийн зохиолч Ялалтын “Төгөлдөр хуурын түүвэр”-ээс жишээлэн үзвэл түүний бүтээлүүд дараах шинжүүдийг агуулж байна. Үүнд:

1. Хэдийвээр олонх нь өрнийн арга техникийг ашиглаж, өрнө дахинаа түгсэн төрөл зүйлээр туурвисан боловч ажиглахаар ерөнхийдээ таван эгшигтийн илэрхийллийн зарчим, хэмнэлийн зураглал, аялгаар монгол хэв маяг, намбыг бүтээлдээ шингээхийг зорьдог.
2. Орчин үеийн шинэ олон янзын арга техникийг ашиглан туршиж, шинэ эрэл хайгуулыг тасралтгүй хийдэг.
3. Сонгодог уламжлалт болон орчин үеийн арга техникийг хослуулан ийнхүү бүтээлээ туурвихдаа хөгжимдөх янз бүрийн арга барил, ардын дуу, бүжгийн хөгжмийн онцлогийг тусган илэрхийлдэг ажээ.

Өвөр монголын хөгжмийн зохиолч Ялалт иймэрхүү туршилт хийж бүтээлүүдээ туурвисан боловч өдгөө энэ түүвэр дэх бүтээлүүдийг хөгжимдөх хүмүүн ховор байх үзэгдэл харагдсан. Зарим нь судалгааны эргэлтэд орж ирсэн ч өргөн дэлгэр судлагдсан байдал харагдахгүй, ихэнх нь зохиогч, зохиолын талаар дөмөгхөн танилцуулсан янзаар өгүүлэлд тусгалаа олсон байна. Тэр утгаар өвөр монгол хөгжмийн зохиолчдын бүтээлийг дэлгэрүүлэн танилцуулах, сургалтад хэрэглэх ажиллагааг бас шаардаж байгаа юм.

## Ашигласан материалын жагсаалт

- Ан Лэ. 2011. “Монгол үндэстний төгөлдөр хуурын бүтээлийн үндэсний онцлог, хувьслын талаарх урьдчилсан судалгаа.” *Улаанхад хотын их сургуулийн сэтгүүл* 3: 164-165.
- Гао Тин. 2007. “Зүүн монголын ардын дуутай төгөлдөр хуурын долоон аялгуу”-ны тухай сэтгэгдэл.” *Өвөр монголын Багшийн их сургуулийн сэтгүүл* 11: 533-535.
- Жанцанноров, Н. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. Улаанбаатар: ШУА-ийн Информатикийн хүрээлэн.
- Ли Ман. 2010. “Шинэчлэл нээлтийн 30 жилийн хугацаан дах Монгол хэв маягийн

төгөлдөр хуурын бүтээлүүдийн судалгаа.” Магистрын судалгааны ажил.,  
Өвөр монголын Багшийн их сургууль.

Мэн Цю. 1997. “А.Шёнбергийн арван хоёр өнгийн техник бий болсон ба Хоуэллийн  
арван хоёр өнгийн техниктэй харьцуулалт.” *Хятадын хөгжим судлал*: 97-113.

Үүдан. 2016. “Ялалтын төгөлдөр хуурын бүтээлийн онцлог ба хөгжимдөх арга  
барилд хийсэн ажиглалт.” Магистрын судалгааны ажил.,Өвөр монголын  
Багшийн их сургууль.

Фэнсон. 2013. “Ялалтын төгөлдөр хуурын бүтээл дэх уран сайхны судалгаа.”  
Магистрын судалгааны ажил., Өвөр монголын Урлагийн их сургууль.

Яруу. 2013. “Монгол хэв маягийн төгөлдөр хуур хөгжмийн судалгаа.” *Урлагийн  
шүүмжлэл* 03/13: 145-148.